17 29

# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 26 өдөр Дугаар А/336 Улаанбаатар хот

## Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Хууль зүйн сайдын “Суралцуулах тухай” 2014 оны Б/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Туслах комиссар Жанчив овогтой Амгаланг ОХУ-ын Жанжин штабын академид магистрантурт, Дэлгэр овогтой Гардийг ОХУ-ын Гадаад Харилцааны яамны дэргэдэх Дипломат академид магистрантурт 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.

Л.ГАНТӨМӨР

910163